



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/39

Тагин

Авто тээврийн хэрэгслийн хяналтын улсын
үзлэг, албан татвар, төлбөр хураах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1, 17.1.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 сарын 06-ны өдрийн А/107 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Адаацаг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, татвар, төлбөр хураалт, техникийн хяналтын үзлэг оношлогоог 2026 оны 06 сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл тооллого явуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Э.Баяржаргал (Санхүүгийн албаны дарга)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхбаяр (Татварын байцаагч)

Гишүүд: О.Анхбаяр (Хэсгийн цагдаа)

Ж.Батжаргал (1 дүгээр багийн Засаг дарга)

Ю.Туяамаа (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Төмөрчөдөр (3 дугаар багийн Засаг дарга)

Э.Сэржмядаг (4 дүгээр багийн Засаг дарга)


Ё.Адилбиш (5 дугаар багийн Засаг дарга)

3. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангаж техникийн хяналтын үзлэг оношлогоонд бүрэн хамруулж, албан татвар, төлбөр хураамжаа төлөхийг тээврийн хэрэгсэл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад даалгасугай.

4893010106

4. Авто тээврийн шинэчилсэн бүртгэл, албан татвар, төлбөр хураах, техникийн хяналтын улсын үзлэг оношлогоо явуулах ажлыг аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/107 захирамжийн дагуу зохион байгуулан, тайланг 9 дүгээр сарын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ